



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 106

Хужирт сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрмодот 1 дүгээр багийн нутаг дэвсгэр “Их нөмөр” гэх газар нутаглаж байгаа малчин Мишигийн Дагвын хотонд 1 нохойнд мал, амьтны халдварт галзуу өвчний шинж тэмдэг илэрч Мал эмнэлгийн тасгийн 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 02 дугаар саналаар 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн 14 хоног хязгаарлалтын дэглэм тогтоосугай.
2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт байгаа 4 хот айлын 10 өрхийн 2985 толгой бог мал, 120 толгой бод малыг галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулж, ариутгал халдваргүйжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг “Гуахарз” мал эмнэлгийн малын их эмч (Д.Даваасүрэн), тухайн өрхийн иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхийг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Ц.Ундрахбаяр), ойр орчимд нутаглаж байгаа айл өрхүүдэд сэрэмжлүүлэг, мэдээлэл хүргэхийг Өвөрмодот 1 дүгээр багийн Засаг дарга (Б.Пагамдулам) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Холбогдох заавар журмын дагуу хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа), Эрэн хайх, аврах бүлгийн дарга, аврах ажиллагааны зааварлагч, дэслэгч (Б.Баярсайхан, Цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгч, дэслэгч (Э.Баатарлхагва) нарт үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТБАЯР

622401011

D:Alban bichig;Zahiramj 202